# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 2025 ОН

2025.12.23

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх** | | | | | | |
| 1 | Засгийн газрын төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1 | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо : | **86** | **138** | Эрүүл мэндийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг 27 чиглэлээр танхим болон цахимаар авах төлөвлөгөөг гаргаж эрүүл мэндийн газрын даргаар батлуулж ажилласан. 57 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 983 эмч, мэргэжилтэн, 39 удаагийн танхимын сургалтад 623 эмч, мэргэжилтэн, улс бүсийн чанартай 8 удаагийн сургалтад 37 эмч, мэргэжилтэн тус тус хамрагдсан байна. ЭМЯ, НҮБ-ийн хүн амын сангийн дэмжлэгтэй “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын үеийн харилцаа холбоо, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг шинжилгээг сайжруулах нь“ сэдэвт сургагч багш бэлтгэх зүүн бүсийн сургалтад 16 эмч мэргэжилтэн, “Сэтгэцийн эрүүл мэнд-2025” олон улсын эрдэм шинжилгээний хуралд 1 эмч, “Сүрьеэг тэглэе-2030” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт сургалтад 7 эмч, мэргэжилтэн, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хавдрын эмч нартай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын эмч нар, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад “Зонхилон тохиолдох хавдрыг эрт илрүүлж, оношлох нь” сэдэвт |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 4 | 4 | |
| | | | Мэргэшүүлсэн сургалт | 20 | 23 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 4 | 6 | |
| | | | Бусад | 58 | 105 | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | **1037** | **1167** | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 887 | 983 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 144 | 178 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 6 | 6 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 1031 | 1161 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтанд хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | **90-ээс дээш** | **98** | сургалтыг зохион байгуулж нийт 56 эмч, мэргэжилтэн хамрагдсан. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад эрүүл мэндийн байгууллагын чанарын алба болон багийн гишүүд оролцсон бөгөөд нийт 122 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтад 3 эмч, мэргэжилтэн, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хавдрын эмч нартай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын эмч нар, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан.<br>Сургалтад аймгийн нэгдсэн эмнэлгийн холбогдох эмч нар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв тус бүрээс нэг их эмч, нэг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нийт 56 эмч, мэргэжилтэн “Дутуу нярайн нүдний эмгэг , эрт илрүүлэг” сэдэвт сургалтыг ЭХЭМҮТөвтэй хамтран нийт 45 эмч, мэргэжилтэнд онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. ТТӨ-ний тархалтын үед ЭХЭМҮТөвийн Амьсгалын эмгэг судлалын эмчээс эмнэлзүйн цахим сургалтыг ЭМБ-уудад зохион байгуулав. Нийт-57 эмч мэргэжилтэн хамрагдсан. ЭМЯ-аас Хүүхдэд тохиолдох томуу болон томуу төст өвчний эмнэлзүйн заавар сэдэвт сургалтад 22 байгууллагын 127 эмч, мэргэжилтэн цахимаар хамрагдсан. ЭХЭМҮТөвд зүрхний эмгэгийг илрүүлэх чадавхжуулах сургалтад анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй нийт 52 эмч, мэргэжилтнийг хамрагдууллаа. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамуулсан гадаад сургалт | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо : | **5** | **7** | Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд анхаарч БНСУ-ын Намъяанжу хотод байрлах Эль (EL) эмнэлэг, Жолла мужийн Чон-Жу хотод байрлах Хью Саранг, эмнэлэгтэй харилцан хөгжих зохилгоор 7 чиглэлд хамтын ажиллагаа солилцооны гэрээг байгуулж ажилласан бөгөөд гэрээний дагуу ЭМГ-1, АНЭ-5, УАУНЭ-1 эмч,анхан шатны ЭМБ-аас 2 х эмч эмнэлгийн мэргэжилтэн 7-21 хонгийн сургалтанд тус тус хамрагдсан байна. Цаашид гэрээний дауу эрүүл мэндийн байгууллагын дарга, эмч эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттайгаар богино хугацааны сургалтанд хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн ЭМХТ, Дадал сумын ЭМТ-тэй хийсэн. Төрийн санхүүжилтээр гадаадад суралцагчтай байгуулах гэрээний дагуу сумын эрүүл мэндийн төвийн 1 их эмч, УАУЭ-ын 1 х эмч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлгийн хороонд 3 сарын сургалтанд хамрагдсан. ОХУ-ын Эрхүү хотын Тарваган тахал судлах эрдэм шинжилгээний хүрээлэнд 10 хоногийн сургалтад 1 их эмч, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Тарваган тахалтай тэмцэх станцад лабораторийн 5 ажилтан “Холер өвчний тандалт, лабораторийн оношлогоо” 5 хононгийн сургалтанд тус тус хамрагдсан. |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагч | **18** | **16** | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 14 | 14 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 4 | 2 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 1 | 1 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 15 | 15 | |
| | | 2.3 | Гадаад сургалтанд хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | **20-оос дээш** | **2** | |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ / сая.төг/ | | | Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж буй орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, чадавхжуулах зорилготой “НУТГИЙН ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийн хүрээнд 16 эмч, сувилагчийг сургаж байгаа бөгөөд тайлант онд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | | | | | | 4 их эмч, 1 эм зүйч, 29 сувилагчийн сургалтын төлбөрт 52,1 сая төгрөг зарцуулсан байна. |
| | | 3.2 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | **15-аас доош** | **12,5** | Нийт нэмэгдсэн албан хаагч - 213 буюу 18,3%, хасагдсан албан хаагч - 192 буюу 12,5% -ийг эзэлж байна. |
| **Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах** | | | | | | |
| 4 | Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1 | Цалин, шагнал, урамшуулалд зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | | | Тайлант онд Эрүүл мэндийн байгууллагуудын нийт урсгал зардал 23,1 тэрбум төгрөг батлагдсанаас урамшуулалд 1.1 тэрбум төгрөг зарцуулсан ба нийт зардлын 3.6 %-ийг эзэлж байна. |
| | | 4.2 | Нэгж албан хаагчид хоол унааны нэмэгдэл /мян.төг/ | | | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 дугаар тушаалын дагуу бүх эрүүл мэндийн байгууллагууд хоногт олгох тогтоосон дүнгээр хоол, унааны нэмэгдлийг тогтмол олгож байна. Мөн 2025 оноос эрүүл мэндийн бүх байгууллага дотоод журамд өөрчлөлт оруулан хоол, унааны зардлыг 10000-20000 болон нэмэгдүүлэн 646,8 сая төгрөг зарцуулсан. |
| 5 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийн бүрдүүлэх | 5.1 | Ажлын байраны таатай орчны сэтгэл ханамжийн санал санал асуулгын дүн (албан хаагчдын сэтгэл ханамж) | 80-с дээш | 89,2 | ЭМБ-ууд албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн эмнэлгийн дотоод үйл ажиллагаанд тохируулан асуултуудыг боловсруулан нийт 34 ЭМБ-аас 3-4 удаагийн судалгааг нэгтгэн харахад дундаж сэтгэл ханамж 89,2% байна. Судалгааны дүнд гарсан санал хүсэлтүүдийг байгууллагын удирдлагуудад танилцуулж асуудлыг шийдвэрлэж ажилласан. /Тайланг хавсаргав/ |
| 6 | Албан хаагчдын эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг | 6.1 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) | 1-ээс дээш | 2 | Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах заалтын хүрээнд зонхилон тохиолдох халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээ, оношилгоог, АШУИС-ийн Япон Монголын эмнэлэг болон Хөх хотын олон улсын монгол эмнэлэг, 4-р төв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлэг, Сүпер ново эмнэлэг, АНЭ мөн бусад улсын болон хувийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. |
| | | 6.2 | Албан хаагчдын хамрагдалт | 90-ээс дээш | 96,3 | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 96,3%. |
| 7 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1 | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ | 138 сая | 298 сая | АЗД-ын мөрийн хөтөлбөр, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 7 албан хаагчид орон сууцны урьдчилгаа, 5 албан хаагчидад гэр олгосон. Мөн дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс төрийн албан хаагчийн орон сууцанд 14 хүнийг, 3 ажилтаныг гэрээр хангаж эмчийн байранд 21 их эмч, 7 сувилагч, 1 бага эмч эмчийн байранд амьдарч ЭМСалбарын эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгаа хангах, буцалтгүй тусламж, тэтгэмж урамшуулал, үзлэг оношилгоо хамруулахад чиглэн 298 сая төгрөгийг зарцуулсан. |
| | **Биелэлтийн хувь** | | | | | **97,9%** |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭЗУТХЭЛТСИЙН ДАРГА Ц.АРИУНТУЯА

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА: Д.ДАШНАМЖИЛМАА